



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/86/СТА-ТШЗ

Цахим хуудас: Bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор хот
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Энхтуяа

Утас: 99449299 Цахим хаяг: tomoo_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.08.27 № 1/285

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Г БӨМБӨГӨР СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЦЭЦГЭЭ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020252

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Д.Цэцэгээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-ноос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймгийн "Глобал капитал Аудит" ХХК-нийн аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2020 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн 10 тоот албан бичгээр 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь тайлант хугацаанд “Сургуулийн өмнөх боловсролыг чанартай хүртээмжтэй олгох” эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, тогтолцооны шинэчлэл хийх
- Боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах
- Төсвийн удирдлага, хэрэгжилтийн чанарыг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний Аcolous программ хангамж ашигладаг байна.

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 21 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны Здугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 235649,2 мянган төгрөгөөс 2,0 хувиар тооцон 4712,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6711,1 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь, материаллаг байдлыг тооцох хувийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9843.4 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0,0	0,0	0
Авлага	773.0		-773.0
Дуусаагүй үйлдвэрлэл			
Бараа материал	56 03.2	61454.1	5050.9
Үндсэн хөрөнгө	688898.0	680971.7	-7927.3
Хуримтлагдсан элэгдэл	-45378.5	-51572,6	-6194,0
Нийт хөрөнгө	700696.7	690853,3	-9843,4
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	700696.7	690853,3	-9843,4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	700696.7	690853,3	-9843,4

Бараа материалын дансны үлдэгдэл 5050.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 78756.1 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бусад эх үүсвэрээс 5890.0 мянган төгрөгийн бараа материал орлого авч 74120.8 мянган төгрөгийн зарцуулж, 5474,4 мянган төгрөгийн бараа акталж, данснаас хассанаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй нөөцөлсөн бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7927.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 310,0 мянган төгрөг, бусад эх үүсвэрээр 1110,0 мянган төгрөг, бүгд 1420,0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 9347,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 690853,3 мянган төгрөг болж 9843,4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө байхгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан тусгай зориулалтын шилжүүлгээс 293490,8 мянган, орон нутгийн төсвөөс 21919,0 мянган, нийт 315409,8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулахаар төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийг бүрэн авч 315315,6 зарцуулан төсвийн хэмнэлтийн 94,2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл ТЗШ-ийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтийг батлагдсан хэмжээнд авч, 315315,6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 186287,8 мянган төгрөг буюу 99,4 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн 3302,4 мянган төгрөг орсныг залруулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 27 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитаар нийт 7629,9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 2389,5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 5237,4 мянган төгрөгийг дахин давтахгүйн зөвлөмж өгөв

Аудитаар дараах 2389,5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас байгууллагын багш, ажилтан нарт Цэцэрлэгийн эрхлэгчийн 2019.12.17-ны өдрийн А/33 тоот тушаалаар 2389,5 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж заалтыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл : Батлагдсан төсөв хэтрэх, Төсвийн тухай хууль зөрчигдөх

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

Аудитаар зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.13. Шилэн дансны мэдээлэл

Бөмбөгөр сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулах үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	140	9	2

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 5 дугаар сарын мэдээ, бүгд 9 мэдээ хугацаа хоцорч мэдээлсэн, 2 мэдээний хугацаа болоогүй байгаа, 2019 оны санхүүгийн тайлангийн аудит дуусангуут хугацаанд нь мэдээгээ байршуулна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлж зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийн хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1. Илрүүлэлт. Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

2.1. Илрүүлэлт:

Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ын суутгалаас бусад суутгалыг бусад өглөг дансаар дамжуулж тооцоогүй нь Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан " " журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөг шилжүүлэн бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн

2.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчиж зардал буруу илэрхийлэгдэх

2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалаар батлагдсан журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн журмыг хатуу мөрдөж, дансны бичилтийг зөв хийж байх.

2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>57,176,257.30</u>	<u>61,454,094.80</u>
33	АВЛАГА	773,053.40	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	773,053.40	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	56,403,203.90	61,454,094.80
351	Түүхий эд материал	28,487,881.53	37,195,893.13
35110	Тусгай зориулалттай материал	28,487,881.53	37,195,893.13
354	Хангамжийн материал	27,915,322.37	24,258,201.67
35410	Бичиг хэргийн материал	476,300.00	148,300.00
35420	Аж ахуйн материал	26,639,022.37	24,109,901.67
35440	Түлш, шатах тослох материал	800,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>643,520,431.53</u>	<u>629,399,163.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	643,520,431.53	629,399,163.33
392	Биет хөрөнгө	636,550,431.53	622,429,163.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	621,324,800.00	621,324,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-10,346,908.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,110,457.00	24,670,228.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,787,352.35	-22,434,166.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,603,483.00	26,116,443.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,591,225.12	-18,791,502.20
39217	Ном	1,890,269.00	1,890,269.00
393	Биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,970,000.00	6,970,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>700,696,688.83</u>	<u>690,853,258.13</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>700,696,688.83</u>	<u>690,853,258.13</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	700,696,688.83	690,853,258.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	219,846,370.54	219,846,370.54
51101	Өмч: - төрийн	219,846,370.54	219,846,370.54
512	Хуримтлагдсан үр дүн	448,058,937.05	438,215,506.35
51210	Өмнөх үеийн үр дүн	448,058,937.05	448,058,937.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-9,843,430.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,791,381.24	32,791,381.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>700,696,688.83</u>	<u>690,853,258.13</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	274,454,149.00	325,712,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,500,000.00	7,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,500,000.00	7,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,500,000.00	7,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,500,000.00	7,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,271,649.00	25,221,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,682,500.00	293,490,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,682,500.00	293,490,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,271,649.00	3,302,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,271,649.00	3,302,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,919,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,919,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280,291,501.20	335,555,630.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,291,501.20	335,555,630.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,234,439.20	332,022,340.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,349,504.00	206,069,990.40
210101	Үндсэн цалин	137,741,306.00	189,605,990.40
210102	Нэмэгдэл	6,306,900.00	6,087,200.00
210104	Урамшуулал	5,707,800.00	6,321,300.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,593,498.00	4,055,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,590,641.00	25,840,000.00
210201	Тэтгэврийн даатгал	14,141,600.00	17,811,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,446,441.00	1,970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,062,500.00	1,576,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	284,000.00	394,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,656,100.00	4,088,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,278,093.00	18,938,073.00
210301	Гэрэл, цахилгаан	4,391,793.00	4,425,473.00
210302	Түлш, халаалт	14,720,000.00	14,312,600.00
210303	Цэвэр, бохир ус	166,300.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,908,300.00	9,907,625.57
210401	Бичиг хэрэг	109,300.00	124,800.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	987,500.00	840,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,180,500.00	1,389,700.00
210404	Ном, хэвлэл	71,800.00	70,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	755,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	559,200.00	1,231,900.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,495,725.57
2105	Нормативт зардал	48,219,400.00	51,410,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,200.00	65,200.00
210502	Хоол, хүнс	47,881,700.00	50,718,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	279,500.00	626,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	191,200.00	1,411,200.00
210604	Урсгал засвар	191,200.00	1,411,200.00
2107	Томилолт, зочны зардал	112,000.00	130,500.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00	130,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,654,349.00	566,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,654,349.00	366,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,930,952.20	17,748,551.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,452,700.00	428,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	323,300.00	1,799,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,154,952.20	15,519,951.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,057,062.00	3,533,290.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,969,400.00	3,439,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,549,400.00	3,302,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	136,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	927.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	927.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,087,662.00	93,263.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,087,662.00	93,263.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-5,837,352.20	-9,843,430.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	593,363,698.26	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	593,363,698.26	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-593,363,698.26	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-599,201,050.46	-9,843,430.70

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	269,954,149.00	318,712,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,954,149.00	318,712,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,682,500.00	293,490,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	267,682,500.00	293,490,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,271,649.00	3,302,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,271,649.00	3,302,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	21,919,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	21,919,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	269,954,149.00	318,712,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,954,149.00	318,712,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,897,087.00	315,175,810.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	158,467,945.00	205,444,737.00
210101	Үндсэн цалин	135,164,345.00	166,256,737.00
210102	Нэмэгдэл	6,306,900.00	16,146,600.00
210104	Урамшуулал	7,610,400.00	12,642,700.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,386,300.00	10,398,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,472,200.00	25,692,200.00
210201	Тэтгэврийн даатгал	13,314,700.00	17,811,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,539,400.00	1,970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,231,500.00	1,576,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	307,900.00	394,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,078,700.00	3,940,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,055,693.00	18,918,073.00
210301	Гэрэл, цахилгаан	4,415,893.00	4,077,773.00
210302	Түлш, халаалт	15,440,000.00	14,640,300.00
210303	Цэвэр, бохир ус	199,800.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,704,200.00	8,157,900.00
210401	Бичиг хэрэг	112,200.00	125,800.00
210402	Тээвэр, шатахуун	790,000.00	840,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,180,500.00	1,409,300.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	62,400.00	69,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	755,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	559,100.00	4,957,900.00
2105	Нормативт зардал	48,477,000.00	51,275,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,200.00	65,200.00
210502	Хоол, хүнс	47,859,700.00	50,583,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	559,100.00	626,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,191,200.00	3,214,300.00
210604	Урсгал засвар	5,191,200.00	3,214,300.00
2107	Томилолт, зочны зардал	112,000.00	130,500.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00	130,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,754,349.00	566,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,754,349.00	366,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,662,500.00	1,776,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,997,700.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	664,800.00	1,776,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,057,062.00	3,536,390.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,969,400.00	3,442,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,549,400.00	3,302,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	139,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	927.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	927.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,087,662.00	93,263.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,087,662.00	93,263.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

					СТ-4А
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					
					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,876,370.54	00.00	453,123,235.85	665,999,606.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,876,370.54	00.00	453,123,235.85	665,999,606.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	6,970.00	00.00	-599,201,050.46	-599,194,080.46
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	448,058,937.05	700,696,688.83
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	448,058,937.05	700,696,688.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	448,058,937.05	700,696,688.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-9,843,430.70	-9,843,430.70
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	219,846,370.54	32,791,381.24	438,215,506.35	690,853,258.13

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	271,494,700.00	255,977,366.00	315,409,800.00	315,315,610.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,494,700.00	255,977,366.00	315,409,800.00	315,315,610.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,893,100.00	247,375,766.00	315,270,000.00	315,175,810.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,648,900.00	151,129,120.00	205,537,300.00	205,444,737.00
210101	Үндсэн цалин	143,021,800.00	132,262,520.00	166,349,300.00	166,256,737.00
210102	Нэмэгдэл	7,412,800.00	7,412,800.00	16,146,600.00	16,146,600.00
210104	Урамшуулал	00.00	2,239,500.00	12,642,700.00	12,642,700.00

**Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210105	Гэрээт ажлын хөлс	9,214,300.00	9,214,300.00	10,398,700.00	10,398,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,561,500.00	17,561,300.00	25,692,200.00	25,692,200.00
210201	Тэтгэврийн даатгал	11,175,400.00	17,561,300.00	17,811,900.00	17,811,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,277,200.00	00.00	1,970,100.00	1,970,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,596,600.00	00.00	1,576,000.00	1,576,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	319,300.00	00.00	394,000.00	394,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,193,000.00	00.00	3,940,200.00	3,940,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,792,300.00	17,780,011.00	18,919,000.00	18,918,073.00
210301	Гэрэл, цахилгаан	3,415,500.00	3,409,211.00	4,078,700.00	4,077,773.00
210302	Түлш, халаалт	14,176,800.00	14,175,400.00	14,640,300.00	14,640,300.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	195,400.00	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,466,500.00	1,466,500.00	8,657,900.00	8,157,900.00
210401	Бичиг хэрэг	126,500.00	126,500.00	125,800.00	125,800.00
210402	Тээвэр, шатахуун	761,700.00	761,700.00	840,000.00	840,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	99,600.00	99,600.00	1,409,300.00	1,409,300.00
210404	Ном, хэвлэл	71,200.00	71,200.00	69,900.00	69,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	755,000.00	755,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	407,500.00	407,500.00	5,457,900.00	4,957,900.00
2105	Нормативт зардал	55,409,200.00	48,117,780.00	50,775,300.00	51,275,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,900.00	44,700.00	65,200.00	65,200.00
210502	Хоол, хүнс	55,351,300.00	48,073,080.00	50,083,400.00	50,583,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00	626,700.00	626,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	261,900.00	261,900.00	3,214,300.00	3,214,300.00
210604	Урсгал засвар	261,900.00	261,900.00	3,214,300.00	3,214,300.00
2107	Томилолт, зочны зардал	150,900.00	150,000.00	130,500.00	130,500.00
210702	Дотоод албан томилолт	150,900.00	150,000.00	130,500.00	130,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,051,300.00	1,048,455.00	566,800.00	566,100.00

Бөмбөгөр сумын Цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,300.00	553,455.00	366,800.00	366,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	200,000.00	200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	495,000.00	495,000.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9550600.00	9860700.00	1776700.00	1776700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,061,400.00	8,507,200.00	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,489,200.00	1,353,500.00	1,776,700.00	1,776,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8601600.00	8601600.00	139800.00	139800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,601,600.00	8,601,600.00	139,800.00	139,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,443,900.00	8,443,900.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	157,700.00	157,700.00	139,800.00	139,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	271,494,700.00	271,494,500.00	315,409,800.00	315,315,610.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	271,494,700.00	271,494,500.00	293,490,800.00	293,397,537.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	271,494,700.00	271,494,500.00	293,490,800.00	293,397,537.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	21,919,000.00	21,918,073.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	21,919,000.00	21,918,073.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	19	19
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	15	15
620003	Үйлчлэх ажилтан	3	3	3	3

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,271,649.00	3,302,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,271,649.00	3,302,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,271,649.00	3,302,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,271,649.00	3,302,400.00
	Мөнгө , түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



Огноо: 2020.02.25